




SOYOLON
ENGINEERING

ТЕХНОЛОГИ ТҮГЭЭЖ
БАЯЛАГ БҮТЭЭНЭ ✓

КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА

**ИНЖЕНЕРИЙН
ЦОГЦ ҮЙЛЧИЛГЭЭ**





СОЁОЛОН ИНЖЕНЕРИНГ ХХК НЬ УУЛ УУРХАЙН САЛБАРТ БАЯЖУУЛАХ БОЛОН БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРҮҮДЭД ИНЖЕНЕРИНГИЙН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭГ ҮЗҮҮЛДЭГ.

БИД БҮХ ТӨРЛИЙН АШИГТ МАЛТМАЛЫН ТӨСЛҮҮДЭД СУУРЬ СУДАЛГААНААС ЭХЛЭЭД ҮЙЛДВЭРЛЭЛИЙН АШИГЛАЛТЫН ШАТАНД ХҮРТЭЛ ТЕХНОЛОГИЙН ШИЙДЛИЙН ЦОГЦ ҮЙЛЧИЛГЭЭГ ХҮРГЭЖ БАЙНА.



АЛСЫН ХАРАА

Салбартаа мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч үлгэр жишээ компани болох



ЭРХЭМ ЗОРИЛГО

Дэвшилтэт техник, технологийг мэргэжлийн ур чадвартай хослуулан эх орныхоо баялаг бүтээх үйлсэд хувь нэмэр оруулна.

БИДНИЙ ҮНЭТ ЗҮЙЛС



ХАРИУЦЛАГАТАЙ БАЙДАЛ

Манай хамт олон аливаа ажлыг цаг хугацаанд нь, чанар/ стандартад нийцсэн байдлаар, захиалагчийн даалгаварт нийцүүлэн хийж гүйцэтгэхэд анхааран ажилладаг.



МЭРГЭШСЭН ХАМТ ОЛОН

Бид тогтмол мэргэжлийн ур чадвараа сайжруулан зогсолтгүй хөгжихийг хичээдэг.



МЭРГЭЖЛИЙН ЁС ЗҮЙ

Аливаа ажил, үйлчилгээндээ инженерийн ёс зүйг баримтлан захиалагч, хэрэглэгчид, хүрээлэн буй орчин, нийгэмдээ үнэнч шударгаар үйлчлэхийг эрмэлздэг.

БИДНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА

01 УУЛ УУРХАЙ, БАЯЖУУЛАХ БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ТӨСЛИЙН СУДАЛГАА (ТЭЗҮ)



Ашигт малтмалын төслүүдийн суурь судалгаанаас эхлэн техник эдийн засгийн үндэслэлийг үе шаттайгаар боловсруулж захиалагчдад шинэлэг үр ашигтай технологийн шийдэл, хөрөнгө оруулалт үйл ажиллагааны зардал багатай байгаль орчинд сөрөг нөлөөгүй, хөдөлмөрийн аюулгүй байдлын шаардлагыг хангасан үр дүнтэй шийдлийг санал болгодог.



СУУРЬ СУДАЛГАА



БҮХ ШАТНЫ ТЕХНИК ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛ –
УРЬДЧИЛСАН ТЭЗҮ, НАРИЙВЧИЛСАН ТЭЗҮ

02 УЙЛДВЭРИЙН НАРИЙВЧИЛСАН ЗУРАГ ТӨСӨЛ



Баяжуулах, боловсруулах үйлдвэрийн нарийвчилсан зураг төслийг оновчтой, үр ашигтай инженерчлэлийн шийдэл дээр үндэслэж механик, цахилгаан, автоматжуулалт, барилга бүтээц зэрэг бүрдлүүдийг багтаасан цогц зураг төсөл хийж гүйцэтгэдэг. Бид зураг төслийг гүйцэтгэхдээ дараах шалгуур үзүүлэлтүүдийг баримтлан ажилладаг:



АШИГЛАЛТ ЯВУУЛАХ,
ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭ
ХИЙХЭД ХЯЛБАР БАЙХ



БАЙГАЛЬ ОРЧИНД ХОР НӨЛӨӨ БАГАТАЙ,
АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ СТАНДАРТ
ШААРДЛАГАД НИЙЦСЭН БАЙХ



БАРИЛГА УГСРАЛТЫН
ГҮЙЦЭТГЭХЭД
ХЯЛБАР БАЙХ



ТӨСӨЛ ГҮЙЦЭТГЭХ ХУГАЦАА БАГА
БАЙХААР ОНОВЧТОЙ ЗӨВ ТӨЛӨВЛӨХ

03 УЙЛДВЭРИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН УГСРАЛТ, СУУРИЛУУЛАЛТЫН ТЕХНОЛОГИЙН ХЯНАЛТ



ЗАХИАЛАГЧИЙН/ТУСГАЙ
ИНЖЕНЕРИЙН ХЯНАЛТ



БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭРҮҮДИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ТЕХНОЛОГИЙН
ХЯНАЛТ, САЙЖРУУЛАЛТ

04 БАЯЖУУЛАХ, БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ТУРШИЛТ ТОХИРУУЛГА, ТОХИРГОО ЖИГДРҮҮЛЭЛТ




МАНАЙ ЗАХИАЛАГЧИД

Бид Монголын томоохон уул уурхайн төслүүдэд ТЭЗҮ, нарийвчилсан зураг төсөл зэрэг төрөл бүрийн инженерчлэлийн зөвлөх үйлчилгээ үзүүлж тэдний итгэл хүлээсэн найдвартай хамтрагчийн нэг болсон байна:



ХАМТЫН АЖИЛЛАГАА:

Бид төслийн онцлог, захиалагчийн шаардлага хүсэлт дээр үндэслэн олон улсын нарийн мэргэжлийн лаборатори, судалгааны шинжилгээний байгууллагууд, тоног төхөөрөмж үйлдвэрлэгчидтэй хамтран ажилладаг:



МЭРГЭЖЛИЙН ПРОГРАММ ХАНГАМЖ



LIMN THE FLOWSHEET PROCESSOR - ыг Монгол албан ёсны төлөөлөх эрхтэйгээр ажилладаг.



AC-TEK Advanced Conveyor Technologies Inc -ын бүтээгдэхүүн конвейерын дизайн тооцоолол хийдэг Sidewinder программыг албан ёсны эрхтэйгээр ашигладаг.

Бид аливаа төслийн инженерчлэлийн тооцоо судалгааг олон жилийн туршлага, мэргэжлийн программ хангамж, олон улсын стандартыг баримтлан хийж гүйцэтгэдэг.



БИДНИЙ АМЖИЛТААС

Бид үйл ажиллагаандаа хариуцлагатай байдал, мэргэжлийн ёс зүй, мэргэшсэн байх зарчмыг ямагт баримталж ирсэн бөгөөд бидний энэхүү хүчин чармайлтыг үнэлж аж үйлдвэр -эрдэс баялгийн яам, монголын уул уурхайн үндэсний ассоциациас 2024 оны “ШИЛДЭГ ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАГЧ”, уул уурхайн зураг төсөл зохиогчдын холбооноос 2023 оны “ШИЛДЭГ УУЛ УУРХАЙН ЗУРАГ ТӨСӨЛ ЗОХИОГЧ” байгууллагаар тус тус өргөмжлөн шагнасан.



“ШИЛДЭГ ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАГЧ”, - АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН ЯАМ, МОНГОЛЫН УУЛ УУРХАЙН ҮНДЭСНИЙ АССОЦИАЦИ, 2024



“ШИЛДЭГ УУЛ УУРХАЙН ЗУРАГ ТӨСӨЛ ЗОХИОГЧ” - МОНГОЛЫН УУЛ УУРХАЙН ЗУРАГ ТӨСӨЛ ЗОХИОГЧДЫН ХОЛБОО, 2023 ОН



“ШИЛДЭГ ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАГЧ”, - АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН ЯАМ, МОНГОЛЫН УУЛ УУРХАЙН ҮНДЭСНИЙ АССОЦИАЦИ, 2024

ЗАХИАЛАГЧДЫН СЭТГЭГДЭЛ



Н. ТЭМҮҮЖИН
ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР –ЭНЕРЖИ РЕСУРС ХХК

“ ҮНЭХЭЭР ЭЭРЭГ ЗАЛУУСААС БҮРДСЭН ГАЙХАЛТАЙ БАГ ХАМТ ОЛОН. БОГИНО ХУГАЦААНД ИХИЙГ БҮТЭЭЖ ЧАДСАН ТА БҮХНИЙ АЖИЛД АМЖИЛТ ХҮСЬЕ! ”



Б.МӨНХ-ЭРДЭНЭ
FLSMIDTH MONGOLIA КОМПАНИЙН БҮС НУТГИЙН АХЛАХ МЕНЕЖЕР

“ БИДНИЙ ХУВЬД, ФЛСМИДТ ГЛОБАЛ БОЛОН ФЛСМИДТ МОНГОЛ КОМПАНИ, СОЁОЛОН ИНЖЕНЕРИНГ КОМПАНИТАЙ ХЭД ХЭДЭН ТӨСӨЛ ДЭЭР ХАМТАРЧ АЖИЛЛАСАН.

МОНГОЛД УУЛ УУРХАЙН БАЯЖУУЛАХ, БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ЗУРАГ ТӨСӨЛ, ДИЗАЙН ГҮЙЦЭТГЭХ АЖИЛ НЬ ШИНЭ ХӨГЖИЖ БУЙ ЧИГЛЭЛ БА ЭНЭХҮҮ АЖЛЫГ ОЛОН УЛСЫН СТАНДАРТЫН ДАГУУ ГҮЙЦЭТГЭЖ БУЙ МОНГОЛ ИНЖЕНЕРҮҮДЭЭС БҮРДСЭН ЭРЧ ХҮЧТЭЙ ХАМТ ОЛОН ГЭЖ БОДДОГ. ”



М. ГАНТУЛГА
ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР ТӨҮГ

“ WE HAD THE OPPORTUNITY TO WORK WITH SOYOLON ENGINEERING LLC ON THE FEASIBILITY STUDY AND ENGINEERING DESIGN WORKS WITHIN THE FRAMEWORK OF ERDENET MINING CORPORATION'S EXPANSION AND MODERNIZATION PROJECTS.

THEIR YOUNG AND CREATIVE TEAM DEMONSTRATED A PROFESSIONAL APPROACH, DELIVERING HIGH-QUALITY OUTCOMES ON TIME. ”

СОЁОЛОНЧУУДЫН ДУУ ХООЛОЙ



Ө. ТЭГШБАЯР
СОЁОЛОН ИНЖЕНЕРИНГ ХХК-ИЙН БАЯЖУУЛАГЧ ИНЖЕНЕР

“ СОЁОЛОН ИНЖЕНЕРИНГ ХХК-Д АЖИЛЛАХААР СОНГОСОН МААНЬ МИНИЙ ХАМГИЙН ЗӨВ ШИЙДВЭРҮҮДИЙН НЭГ ГЭЖ БОДДОГ. ЭНЭ ХАМТ ОЛОНТОЙГОО ХАМТДАА БҮТЭЭЖ, ШИНЭ МЭДЛЭГ, ТУРШЛАГА ХУРИМТЛУУЛСНААР ЗӨВХӨН МИНИЙ БИШ КОМПАНИЙН ҮНЭ ЦЭНЭ Ч НЭМЭГДЭЖ БАЙГААГ АНЗААРДАГ. ”

ӨНГӨРСӨН ХУГАЦААНД ОЛОН ЧУХАЛ ТӨСЛИЙГ АМЖИЛТТАЙ ХЭРЭГЖҮҮЛСЭН НЬ БИДНИЙ ХАМТЫН ХҮЧ, МЭРГЭЖЛИЙН УР ЧАДВАРЫН БАТАЛГАА БӨГӨӨД ХАМТ ОЛНООРОО БАХАРХАХ СЭТГЭЛИЙГ ТӨРҮҮЛДЭГ. ”



Г.БУМ-ЭРДЭНЭ
СОЁОЛОН ИНЖЕНЕРИНГ ХХК-АХЛАХ ИНЖЕНЕР

“ ТӨСӨЛ БҮРИЙН ОНЦЛОГ НЬ ӨРГӨН ХҮРЭЭНД АСУУДАЛ ШИЙДВЭРЛЭХ СОРИЛТ ҮҮСГЭДЭГ БА ТУХАЙН СОРИЛТЫГ ДАВАХЫН ТУЛД ӨӨРИЙГӨӨ ХӨГЖҮҮЛЭХЭД ҮРГЭЛЖ ДЭМЖДЭГ УДИРДЛАГА, ХЭЗЭЭД НЭЭЛТТЭЙ ХАМТ ОЛОНТОЙ БОЛОХООР БИ СОЁОЛОН ИНЖЕНЕРИНГ ХХК-Д АЖИЛЛАХДАА ДҮРТЭЙ БАЙДАГ. ”

МӨН КОМПАНИЙ ЗҮГЭЭС ХУВЬ ХҮН БОЛОН МЭРГЭЖЛИЙН ЧИГЛЭЛИЙН СУРГАЛТУУД, СПОРТООР ХИЧЭЭЛЛЭХ ЗЭРГЭЭР ТОГТМОЛ АЖИЛТНУУДЫНХАА МЭДЛЭГ ЧАДВАР, ЭРҮҮЛ МЭНДЭД АНХААРДАГ НЬ ТААЛАГДДАГ. ”



Г. БУДРАГЧАА
СОЁОЛОН ИНЖЕНЕРИНГ ХХК-ИЙН МЕХАНИК ИНЖЕНЕР

“ СОЁОЛОН ИНЖЕНЕРИНГ КОМПАНИД АЖИЛЛАХ БОЛСОН ХАМГИЙН ТОМ ШАЛТГААН БОЛ ТӨСӨЛ БҮР ӨӨРИЙН ОНЦЛОГ, СОРИЛТТОЙ БАЙДАГ НЬ НЭГЭН ХЭВИЙН БУС, ҮРГЭЛЖ ШИНЭ ЗҮЙЛ СУРАХ БОЛОМЖ ОЛГОДОГТ ОРШДОГ. ЭНЭ НЬ НАДАД ДАСАН ЗОХИЦОХ ЧАДВАР, МЭРГЭЖЛИЙН УР ЧАДВАРАА УЛАМ ХӨГЖҮҮЛЭХ СУУРЬ БОЛЖ ӨГДӨГ. ӨӨРИЙН ГАРГАСАН ДИЗАЙН, ИНЖЕНЕРИЙН ШИЙДЭЛ БОДИТООР ХЭРЭГЖИЖ, БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН НЭГ ХЭСЭГ БОЛОН БИЕЛЛЭЭ ОЛЖ БУЙГ ХАРАХ МЭДРЭМЖ ХАМГИЙН БАХАРХАМ, УРАМТАЙ МӨЧҮҮДИЙН НЭГ ЮМ. СОЁОЛОНД АЖИЛЛАЖ ЭХЭЛСНЭЭС ХОЙШ БИ МЭРГЭЖЛЭЭ ИЛҮҮ ГҮНЭГИЙ ОЙЛГОЖ, ИХИЙГ СУРАХ ХЭРЭГТЭЙ ГЭДГЭЭ МЭДЭРСЭН. ЭНЭ ОРЧИН НАДАД УРАМ ЗОРИГ, ХИЧЭЭЛ ЗҮТГЭЛЭЭ УЛАМ НЭМЭГДҮҮЛЭХ ЭРЧ ХҮЧИЙГ ӨГЧ БАЙНА ”





ГҮЙЦЭТГЭСЭН ТӨСЛҮҮД



2021-2022 ОН

УРДЧИЛСАН ТЭЗҮ/ НАРИЙВЧИЛСАН ТЭЗҮ /
ЗАХИАЛАГЧ: ТАВАНТОЛГОЙ ТӨМӨРЗАМ ХХК

ТАВАНТОЛГОЙН НҮҮРС АЧИХ ЛОГИСТИКИЙН ТӨВ

УГ ТӨСӨЛ НЬ ТАВАНТОЛГОЙН ОРДЫН ТҮҮХИЙ НҮҮРСИЙГ
БУТЛАЖ, ХОЛИЛТ- ЧАНАРЫН ДУНДАЖЛАЛТ ХИЙЖ ОВООЛГО
ҮҮСГЭН, ВАГОНД АЧИХ ЗОРИУЛАЛТТАЙ ИНЖЕНЕРИНГИЙН
БАЙГУУЛАМЖИЙН ТӨСӨЛ ЮМ:

- Түүхий нүүрс -300 мм хүртэл бутлах анхан шатны бутлуур
- Автомат дээжлэгч, конвейерийн жингээр тоноглогдсон нийт 2.2км урт туузан конвейер
- Бутлагдсан нүүрсийг чанарын дундажлалт хийх овоологч
- Түүхий нүүрсийг овоолгоос дундажлан ачих Хүрдэн тэжээгч
- Бутлагдсан, чанарын дундажлалт хийгдсэн нүүрсийг вагонд ачих байгууламж, тоос дарах системээс бүрдэнэ.



ЖИЛИЙН ХҮЧИН ЧАДАЛ:

20 САЯ ТОН/ЖИЛ – 3500 ТОН/ЦАГ

2021-2022 ОН

ТАВАНТОЛГОЙН НҮҮРС АЧИХ ЛОГИСТИКИЙН ТӨВ

2022-2023 ОН

НАРИЙВЧИЛСАН ЗУРАГ
ТӨСЛИЙНХӨРВҮҮЛЭГ БАТАЛГААЖУУЛАЛТ



ТАВАНТОЛГОЙН НҮҮРС АЧИХ
ЛОГИСТИКИЙН ТӨВИЙН АЖЛЫН
ЗУРАГ ТӨСЛИЙН:

- Технологийн зураг төсөл
- Барилга бүтээцийн зураг төсөл
- Цахилаан автоматжуулалтын зураг төсөл
- Төслийн нэгдсэн төсвийг хийж гүйцэтгэн мэргэжлийн байгууллагаар магадлуулж захиалагчид хүлээлгэж өгсөн.



ЖИЛИЙН ХҮЧИН ЧАДАЛ:

20 САЯ ТОН/ЖИЛ



ЗАХИАЛАГЧ: TECHGART BEIJING
ENGINEERING COMPANY

ОВООТ ТОЛГОЙН ОРДЫН НҮҮРСИЙГ ХУУРАЙГААР БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР

УГ ТӨСӨЛ НЬ ОВООТ ТОЛГОЙН УУРХАЙН НҮҮРСИЙГ ХУУРАЙ
АРГААР БАЯЖУУЛАХ ТӨСӨЛ ЮМ:

- Эргэлтэт бутлуур – 1000 тон/цаг
- FGX хуурай ангилагч – 480 тон/цаг болон бүтээгдэхүүн, хаягдал тээвэрлэгч конвейерын систем зэргээс бүрдэнэ.

ТЕХНИК ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛ
/ НАРИЙВЧИЛСАН ЗУРАГ ТӨСӨЛ

ЗАХИАЛАГЧ:
САУСГОБИ СЭНДС ХХК



ЖИЛИЙН ХҮЧИН ЧАДАЛ:
2.3 САЯ ТОН/ЖИЛ



2021-2023 ОН

АЛТАН ШИРЭЭ АЖ ҮЙЛДВЭРИЙН ПАРКЫН ШИРЭМ ҮЙЛДВЭРЛЭХ ТӨСЛИЙН ТЭЗҮ

УГ ТӨСӨЛ НЬ ТӨМРИЙН НОЙТОН БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР,
НҮҮРС БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭРЛЭХ, КОКСЫН ҮЙЛДВЭР,
ХОРГОЛЖИЙН ҮЙЛДВЭРЭЭС БҮРДЭХ АЛТАН ШИРЭЭ АЖ
ҮЙЛДВЭРИЙН ЦОГЦОЛБОРЫН НЭГ ХЭСЭГ ЮМ.

450 МЗ ЭЗЭЛХҮҮНТЭЙ ДОМЕН ЗУУХНЫ
ТЕХНОЛОГИОР ШИРЭМ ҮЙЛДВЭРЛЭХ
ТӨСЛИЙН ТЭЗҮ

ЗАХИАЛАГЧ:
ИНФИНИТИ СПЕЙСХХК



ЖИЛИЙН ХҮЧИН ЧАДАЛ:
500 МЯН.ТОН



2023 ОН





ГҮЙЦЭТГЭСЭН ТӨСЛҮҮД

ХҮДЭР БЭЛТГЭЛИЙН I ШУГАМЫН ӨРГӨТГӨЛИЙН ТӨСЛИЙН ТЭЗҮ, ЗУРАГ ТӨСӨЛ

2023 ОН



- Технологийн онцлог: 2 x 3500 тон/цаг хүчин чадалтай анхдагч бутлуур, 2 x 2250 тон/цаг хүчин чадалтай HPGR
- DRA Global, JKsimmet зэрэг олон улсын судалгааны төв, зөвлөхүүдтэй хамтарч ажилласан.
- Энэхүү төсөл нь барилга угсралт хийгдэж ашиглалтанд орсноор Монгол анх удаа HPGR буюу өндөр даралтын булт бутлуур суурилуулсан төсөл болох юм.




ЖИЛИЙН ХҮЧИН ЧАДАЛ:
20.5 САЯ ТОН/ЖИЛ



ЗАХИАЛАГЧ:
ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР ТӨҮГ

“БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ХАЯГДЛЫГ ӨТГӨРҮҮЛЭХ ТЕХНОЛОГИ НЭВТРҮҮЛЭХ ТӨСӨЛ” – ТЕХНОЛОГИЙН НАРИЙВЧИЛСАН ТООЦООЛОЛ, АЖЛЫН ЗУРАГ ТӨСӨЛ



2023 ОНЫ 1 САРААС – 2024 ОНЫ 6 САР

- Технологийн онцлог: 2 x D 80 м диаметртэй өндөр хурдны өтгөрүүлэгч, 2 шатлалт өтгөрсөн булингийн насосны систем, Эргэлийн усны насосны систем, флокулянтны систем зэрэг барилга байгууламжуудаас бүрдсэн төсөл юм.
- Энэ төсөлд ATC Williams -ын зөвлөхүүдтэй хамтарч ажилласан.




ЖИЛИЙН ХҮЧИН ЧАДАЛ:
БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН 40 САЯ ТОН/ЖИЛ ХҮДЭР БОЛОВСРУУЛАХ ХҮЧИН ЧАДАЛ ДЭЭР ҮНДЭСЛЭСЭН.



ЗАХИАЛАГЧ:
ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР ТӨҮГ

УХААХУДАГ УУРХАЙН “НҮҮРС БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ХАЯГДЛЫГ УСГҮЙЖҮҮЛЭХ ҮЙЛДВЭРИЙН ӨРГӨТГӨЛИЙН ЗУРАГ ТӨСӨЛ

2024 ОНЫ 1 САРААС – 2024 ОНЫ 9 САР



- Жилийн хүчин чадал: жилийн 15 сая тон нүүрс баяжуулах үйлдвэрийн флотацийн хаягдлыг усгүйжүүлэх үйлдвэрийн өргөтгөл. Энэхүү зураг төслийн дагуу өргөтгөл хийгдсэнээр хаягдал усгүйжүүлэх үйлдвэрийн хүчин чадал 2 дахин нэмэгдэх юм.
- Технологийн онцлог: төсөл нь 2 фильтр прессээс бүрдэх бөгөөд 40-45 % хатуулгийн агуулгатай өтгөрсөн булингыг фильтр прессээр шахаж 20-22% чийглэгтэй хатуу хаягдал гаргаж эргэлтийн усыг үйлдвэрийн технологийн ус руу нийлүүлнэ.



ЗАХИАЛАГЧ:
ЭНЕРЖИ РЕСУРС ХХК



